



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/171

Чингис хот

**Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан
шалгах комиссын дүрэмийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүний дагаж мөрдөх дүрмийг хавсралтаар баталсугай.

2.Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын уялдаа холбоотой ажиллахыг Баримт нягтлан шалгах комиссын даргад, дүрэмд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнд тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/46 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 12-ны өдрийн 07/17/21
дугаар захирамжийн хавсралт

БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комисс (цаашид “БНШК” гэх) Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон бусад бусад хууль, эрхзүйн акт энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

Хоёр. Байгууллагын БНШК-ын зорилго

2.1. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан архивт шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулах,

2.2. Байнгын хадгалатад баримт сонгох болон төрийн архивт баримт шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах,

2.3. Устгах баримтын жагсаалтыг комиссын хурлаар хэлэлцэн баталж, зохих төрийн архиваас зөвшөөрөл авсны үндсэн дээр устгах ажлыг зохион байгуулах

Гурав. Байгууллагын БНШК-ын зохион байгуулалт

3.1. Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх БНШК нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба комиссын даргаар Тамгын газрын дарга байна.

3.2. БНШК нь аймгийн Архивын дэргэдэх БНШАЗК-оос арга зүйн зөвлөгөө авч ажиллана.

3.3. БНШК нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хуралдан, хурлын шийдвэрийг гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлаар шийдэрлэх асуудлыг комиссын нарийн бичгийн дарга гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.4. Хурлыг тэмдэглэлийг комиссын нарийн бичгийн дарга хөтлөн, комиссын даргын гарын үсэг болон байгууллагын тэмдгээр баталгаажуулна.

3.5. Байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт, байнга, түр хадгалах баримтын бүртгэл, устгах хэргийн акт зэргийг хянан хэлэлцэх уг баримт бичгүүдийг аймгийн Архивын тасгаар хянуулна.

3.6. Байнга хадгалах баримтуудыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйл заасан хугацаагаар байгууллагын архивт хадгалсаны дараа холбогдох төрийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

Дөрөв. БНШК-ийн үүрэг

4.1.Байгууллагын баримт хадгалах хугацааны жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, устгах хэргийн актыг хянан хэлэлцэх,

4.2.Байнга, түр хадгалах хэргүүд болон устгах хэргийг ялгах ажлыг жил бүр зохион байгуулах,

4.3.Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

